



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 9/25

Эмээлтолгой

Сумын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт,  
2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:


1. Сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэсүгэй.
2. Сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Төлөвлөгөөг зорилт, арга хэмжээ бүрээр хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Мөнхжаргал)- д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Уранчимэг)-д даалгасугай.

ДАРГА  П.БАЯРСАЙХАН



1519063

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн ээлжит IX хуралдааны 9/25 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМ

ЖАРГАЛАНТ СУМЫН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Бодлогын үндэслэл	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт хэмжих нэгж	Үр дүнгийн		Шаардлагатай хөрөнгө Санхүүжилтийн хэмжээ /сая.төг/	Үндсэн хариуцагч	Хамтрагч
				Суурь түвшин /2022 он/	Зорилтот түвшин /2023 он/			
1	2	3	4	5	6	7	8	9
<b>НЭГ ХУНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
<b>1.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл</b>								
1.1.1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.3 дахь заалт	Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан эрт илрүүлэг үзлэгийг чанаржуулах	Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувь	Баянхонгор аймагт урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах 2150 хүнээс 72 хүн хамрагдаж, 33 хувь -Сумд үзүүлэх 1900 хүнээс 1420 хүн хамрагдаж, 74 хувьтай байна.	100 хувьд хүргэх	-	Эрүүл мэндийн төв	Нийгмийн бодлогын мэргэжилтэн Багийн Засаг дарга нар
1.1.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2 дахь заалт	Шаардлагатай үед ажиллах эмч, эмнэлгийн байгууллагын ажилтны нөөцийг бүрдүүлэх, сургах	Шаардлага -тай эмнэлгийн мэргэжилтний тоогоор	Багийн эмч-2	Шүдний эмчтэй болох Багийн эмч-3	5.000.000	Эрүүл мэндийн төв	Сумын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9
1.1.3	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.3 дахь заалт	Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	30	100 хувь	-	Эрүүл мэндийн төв	Багийн Засаг дарга нар
<b>1.2.Идэвхтэй амьдрал-Эрүүл Монгол хүн</b>								
1.2.1	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.3.2.Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.2 дахь заалт	Улс тив дэлхий, улсын хэмжээний тэмцээнд амжилт үзүүлсэн тамирчдад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн тамирчдын тоо	0	Амжилт гаргасан тамирчдад дэмжлэг үзүүлсэн байх	5.000.000	Сумын Засаг дарга	Соёлын төв
1.2.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2 дахь заалт	Уран бүтээлч, уран бүтээлийг аймаг, улсын болон олон улсын тэмцээн, наадамд оролцуулахад дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн тоогоор	Аймгийн аварга шалгаруулах "Өвлөн бүжье" тэмцээн уралдаанд шатахууны дэмжлэг үзүүлсэн. /1 удаа/	5	5.000.000	Сумын Засаг дарга	Соёлын төв
1.2.3	Биеийн спортын тухай хууль	Спортын оны аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулах	Тэмцээн зохион байгуулснаар	1	1	3.000.000	Биеийн тамирын арга зүйч	ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9
1.2.4	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн дахь заалт 3.1.3	"Залуу гэр бүл" хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх	Төсөл хэрэгжүүлснээр	0	1	-	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Багийн Засаг дарга нар
<b>1.3.Боловсролын чанар-Хөгжлийн тулгуур</b>								
1.3.1	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн дахь заалт 2.1.2	Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон, иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлснээр	70 хувь	100	-	Ерөнхий боловсролын сургууль	Хэлний бодлогын зөвлөл
1.3.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн дахь заалт 2.2.2	Төрийн албан хаагчдын компьютер дээрх монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх	Монгол бичгийн хэрэглээ нэмэгдснээр	70	100	-	Ерөнхий боловсролын сургууль	Хэлний бодлогын зөвлөл Байгууллагын дарга, зрхлэгч нар
1.3.3	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн дахь заалт 2.2.3	Сум орон нутгийн онцлог, нөөц, боломжид тулгуурлан сурагчдын хөдөлмөр зуслан байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Хөдөлмөр зуслан ажиллуулах	0	1	-	Ерөнхий боловсролын сургууль	Сумын ЗДТГ
1.3.4	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн дахь заалт 2.2.3	Сургууль, цэцэрлэгийн хичээлийн байрны ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэх	Ашиглалтад орсноор	0	1	Улсын төсвөөс	Ерөнхий боловсролын сургууль	Сумын Засаг дарга

1	2	3	4	5	6	7	8	9
<b>1.4.Техонлогийн дэвшил-Шинэ санаа-Шилдэг бүтээл</b>								
1.4.1	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1, 2.4.5 дахь заалт	Орон нутгийн хөгжил, ирээдүйн төлөвлөлтөд үнэтэй хувь нэмэр болохуйц шинэ санаа, дэвшилт техонлоги нэвтрүүлэх уралдааныг иргэдийн дунд зарлах	Шинэ санаа, дэвшилтэд техонлоги нэвтрүүлэх	0	1	1.000.000	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Сумын ЗДТГ
<b>1.5.Халамжаас-Хөдөлмөрт</b>								
1.5.1	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.1.1, 3.1.2 Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.1 дэх заалт	Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх	Ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	Тухайн онд ажил хайгчаар бүртгүүлсэн-15 Бүтээн байгуулалтын ажил болон байнгын, түр ажлын байранд-35 иргэн жуулчилсан байна.	50	-	Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн	Сумын ЗДТГ
1.5.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1 дэх заалт	ЖДҮ эрхлэгчдийг дэмжих, үйлдвэржилтийн бодлоготой уялдуулж /СХС, ЖДҮС/ зээл олгох, зээлийн үр дүнд тавих хяналтыг сайжруулах	Зээл олголт Зээл төлөлтийн хувиар	Зээл олголт 16 сая -Хугацаа хэтэрсэн иргэдээс 1 иргэн зээл хаасан.	30 -Хугацаа хэтэрсэн	Хоршоо хөгжүүлэх сангаас	Зөвлөл	Сумын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9
1.5.3	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.1.1, 3.1.2 Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1 дэх заалт	Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангах	Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн тоо	Нийгмийн даатгалын сайн дурын даатгал-38 иргэн төлж 71 хувь Эрүүл мэндийн даатгал-306 иргэн төлсөн.	80 хувь	-	Нийгмийн даатгалын байцаагч	Багийн Засаг дарга нар
1.5.4	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.1.1, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.4 дэх заалт	Зорилтот бүлгийн иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах	Ажлын байранд зуучилсан иргэдийн тоо	4	10	-	Халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
<b>1.6.Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ</b>								
1.6.1	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.1, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1, сумын Засаг даргын 2021-2024 үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2 дахь заалт	Түүх соёлын дурсгалт газар, соёлын биет болон биет бус өвийг өвлөн уламжлагчдыг илрүүлэх, сурталчлах, дэмжихэд чиглэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	Оролцогчдын тоо	1 удаа	2	-	Соёлын төв	Төрийн байгууллагууд

1	2	3	4	5	6	7	8	9
1.6.2	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.3.7, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.8.6, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.3 дахь заалт	Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх	Угийн бичиг хөтөлтийн хувь	23 хувь	50 хувь	2.000.000	Соёлын төв	Сумын ИТХ, ЗДТГ Багийн Засаг дарга нар
1.6.3	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3 дахь заалт	Алслагдсан сум, багийн малчдад зориулсан соёл хүмүүжлийн олон талт арга хэмжээ зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулсан сумын тоо	0	1	Байгууллагын төсөв	Соёлын төв	Багийн Засаг дарга нар
1.6.4	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад холбогдох хууль Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 8.1.3	Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа, Хууль сурталчлах нээлттэй өдөрлөг зохион байгуулах	Өдөрлөг зохион байгуулж, үр дүнг тооцсноор	Сургалт сурталчилгаа-800 иргэн	Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны тоо Өдөрлөг-1 Сургалт сурталчилгаа-1000	-	Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн	Нийгмийн бодлогын мэргэжилтэн

1	2	3	4	5	6	7	8	9
<b>ХОЁР-ЭДИЙН ЗАСАГ</b>								
<b>2.1. Санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна.</b>								
2.1.1	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1 дэх заалт	Төрийн байгууллагууд санхүүгийн зөрчилгүй ажиллах, орон нутгийн хөгжлийн сангийн журмыг хэрэгжүүлэх, хяналтыг сайжруулах	Ажил сайжруулах төлөвлөгөө гаргаж ажилласан байх	Зөрчилтэй	Зөрчилгүй ажиллах	-	Санхүүгийн алба	Байгууллагын дарга, эрхлэгч нар
2.1.2	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.1.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.1 дэх заалт	Татварын орлогыг бүрдүүлэх Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүрэн холбох, төлбөрийн баримт олголтын хувийг 90-ээс дээш хувьд хүргэх	Төлбөрийн баримт олголтын хувь	Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системд холбогдсон 13 үйлчилгээний байгууллага холбогдсон.	90 хувь	-	Татварын Улсын байцаагч	Багийн Засаг дарга нар
2.1.3	Татварын ерөнхий хууль	Татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх		2022 татвар төлөгчдийн баярыг сурагчдын дунд тэмдэглэн өнгөрүүлсэн.	Нийт иргэдийн дунд зохион байгуулах	Засаг даргын нөөц хөрөнгө 1 сая	Татварын Улсын байцаагч	Сумын ЗДТГ
<b>2.2. Өрсөлдөх чадвартай бренд бүтээгдэхүүн</b>								
2.2.1	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.8, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.9.2 дахь заалт	Аймаг, орон нутаг үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, бренд бүтээгдэхүүн бий болгох зорилгоор "НЭГ ӨРХ, НЭГ БАЙГУУЛЛАГА, НЭГ СУМ-НЭГ БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН,	Орон нутаг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо	Нутгийн бренд цагаан идээний багц, мөн 2 иргэн хатуу саван үйлдвэрлэн сумын дэлгүүрүүдээр худалдаалж байгаа бол 1 иргэн хүүхдийн эсгий гутал, тавчик, улавч үйлдвэрлэн сум, аймгийн иргэдэд худалдаалж	Бренд бүтээгдэхүүн-ий тоог нэмэгдүүлэх Тоо 5-аас дээш	-	ХАА-н тасгийн мэргэжилтэн	Сумын ЗДТГ



		ҮЙЛЧИЛГЭЭ" шалгаруулах болзолт уралдаан зарлаж, шалгарсан бүтээгдэхүүнүүдийг бодлогоор дэмжих		Баянхонгор хөгжил корпорациас төслийн зээл авч бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлэн ажиллаж байна. -Бүтээлч үйлдвэрлэл-2022 үзэсгэлэн зохион байгуулсан.				
<b>2.3.Эрүүл хөрс-Эрүүл хүнс</b>								
2.3.1	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.12, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.8.4 дэх заалт	Үлийн цагаан оготны судалгаа хийж, устгалын ажил зохион байгуулах	Устгал хийгдсэн талбайн хэмжээ /мян.га/	10 сая төгрөгөөр 2 багийн нутагт устгал зохион байгуулсан.	3 багийн нутагт зохион байгуулах	ОНХсан 20 сая	ХАА-н тасаг	Багийн Засаг дарга нар Байгаль орчны хэсэг
2.3.2	Тариалангийн тухай хуулийн 19.5.5, "Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 278 дугаар тогтоол, тус хөтөлбөрийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 8.1.13, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.9.4,	Хамгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж, нэгдсэн зохион байгуулалттайгаар хүлэмж нийлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	Тариалалт нэмэгдүүлэх Хүлэмжийн тоо	Хүнсний ногооны үрийг татан авч төмс, хүнсний ногооны тариалалт эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэж ажилласан. -Нийт хүн амын 10 хувь -ХАА-н тоног төхөөрөмж, үр бордоо, үрсэлгээний үзэсгэлэн худалдаагаар дамжуулан 2 иргэн 3х8тай хүлэмж 2 ширхэг, 1 иргэн 6х10тай хүлэмж 1 ширхэгийг тус тус	Тариалалтыг өмнөх оноос 5 хувиар нэмэгдүүлэх Хүлэмж-4	-	ХАА-н тасаг	Сумын иргэд Байгаль орчны хэсэг

	3.9.5 дахь заалт			худалдан авч, үр үрсэлгээг хийж, хамгаалалттай хөрсний тариалалт эрхэлж байна.				
<b>2.4.Ашиг шимтэй эрүүл мал</b>								
2.4.1	Сумын Засаг даргын 2021-2024 оны жил ажиллагааны хөтөлбөрийн 6.2.1 дэх заалт	Малыг эрүүлжүүлэх, удмын санг сайжруулах, нутгийн шилмэл омог үүлдэрийн малыг өсгөн эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна.	Зохион байгуулсан ажлын үр дүнгээр	2 суурьт ялган суурилсан, 147 хуц, 120 ухнанд хавар, намрын үзлэг ангилалтыг нь зохион байгуулсан. Хуц хаврын амьдын жингийн дундаж 62 кг, намрын амьдын жингийн дундаж 79.5 кг, ухна хаврын амьдын жингийн дундаж 41 кг, намрын амьдын жингийн дундаж 56.5 кг байна.	Сайн үүлдрийн хээлтүүлэгч худалдан авч, сүргийн таваарлаг байдлыг сайжруулна. Хээлтүүлэгчийн үзлэг ангилалтыг зохион байгуулах	ОНХСан 8.000.000 төгрөг	ХАА-н тасаг	Мал эмнэлгийн тасаг
		Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	Үйлчилгээ сайжирсан байна. тоног төхөөрөмж нэмэгдүүлсэн байна.	Угаалгын ванн-3 Тарилгын хашаа-8	Угаалгын ванн-5 Тарилгын хашаа-9 Тоног төхөөрөмж нэмэгдүүлсэн байна.	61 сая	Мал эмнэлгийн тасаг	Сумын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9
2.4.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2.2 дахь заалт	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж нийгмийн баталгааг хангах	Даатгалд хамрагдсан хувиар	Даатгалд банкуудаар дамжуулан 136 малчин, мал бүхий өрх малын даатгал хийлгэсэн. Өмнөх онтой харьцуулахад сайн дурын даатгалд хамрагдалт 20 хувиар өссөн.	20 хувиар өсгөх	-	Багийн Засаг дарга нар	Мал эмнэлгийн тасаг ХАА-н тасаг
<b>ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
<b>3.1.Байгалиа хайрлая-Ногоон байгууламж</b>								
3.1.1	Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай зарлиг, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.6.6, 5.1.8, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.1.1 дэх заалт	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	Тарьсан модны тоо	2379 мод шинээр тарьсан. Арчилгаа хийж, ургуулсан.	Арчилгааг сайжруулж, мод ургуулах өмнөх оноос 10 хувиар өсгөх	-	Байгаль орчны хэсэг	Иргэд, албан байгууллага
3.1.2	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.5, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.1.1	Биотехникийн арга хэмжээ авах /амьтдын байршил бүхий газруудад хужир, мараа, өвс, тэжээл, хорголжин байршуулах/	Давтамжийн тоо	хужир 1.8 тн хужирыг 6 удаа тавьж өгсөн	2,5 тн	Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс	Байгаль орчны хэсэг	Сумын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9
3.1.3	"Алсын хараа 2050" урт хугацааны бодлогын баримт бичгийн 6.3.5, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.1.6, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.2 дахь заалт	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтын зураглал хийж баталгаажуулах	Хамгаалалтын бүсийн зураглал хийж, кадастрын санд бүртгэсэн сумын тоо	1	3	-	Байгаль орчны хэсэг	Сумын ЗДТГ
3.1.4	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 51.4, 5.2 дахь заалт	Усны нөөцийн хомстол бохирдлоос хамгаалах, усны зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг өргөн зохион байгуулах	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2	5	-	Байгаль орчны хэсэг	Багийн Засаг дарга
<b>3.2.Хоггүй сум-Хөрсний бохирдлоос сэргийлье</b>								
3.2.1	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.1.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.3 дахь заалт	Сумын гэр хороололд "Эко" 00 нэмэгдүүлэх	Эко ариун цэврийн байгууламжтай болсон өрхийн тоо	2	5	-	Байгаль орчны хэсэг	Багийн Засаг дарга Н.Ганжаргал Эрүүл мэндийн төв

1	2	3	4	5	6	7	8	9
3.2.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.1.1 дэх заалт	Байгальд зэлтэй орон нутаг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байгальд ээлтэй, байгалиа хайрладаг байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн тоог нэмэгдүүлэн ажиллана.	Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгээр	0	Төлөвлөгөө гаргаж, үр дүнг тооцож ажилласан байна.	5.000.000	Байгаль орчны хэсэг	Иргэд, албан байгууллага
3.2.3		Хог хаягдлын менежментын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	Үр дүнгээр	0	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	5.000.000	Байгаль орчны хэсэг	Иргэд, албан байгууллага Багийн Засаг дарга нар
<b>3.3.Газар эзэмших, ашиглах</b>								
3.3.1	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 7.2.1 дэх заалт	Шинэ суурьшлын бүсийг бий болгоно.	Бүс бий болсноор	0	1		Газрын даамал	Сумын Засаг дарга
<b>ДӨРӨВ.ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>								
<b>4.1.Ээлтэй төлөвлөлт</b>								
4.1.1	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.2 дахь заалт	Төрийн албаны хүний нөөцийн урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, алба хаагчдыг бэлтгэж, чадавхжуулна.	Боловсон хүчнээр бүрэн хангагдсан байна	0	1		Тамгын газрын дарга	Ажлын хэсэг
4.1.2	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1 дэх заалт	Төвлөрсөн халаалт болон цэвэр усны шугам сүлжээнд холбогдсон албан байгууллага, айл өрхийн тоог нэмэгдүүлэх, сайжруулах	Өмнөх онтой харьцуулахад өссөн байх	Төрийн байгууллагууд бүгд холбогдсон. Хувийн хэвшил-2 Орон сууц холбогдсон.	Иргэн, аж ахуй нэгжүүдийг холбох		Сумын ИТХ, ЗДТГ	Аж ахуй нэгж

1	2	3	4	5	6	7	8	9
4.1.3	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1 дэх заалт	Эрчим хүчний шугам сүлжээнд өргөтөл хийх	Өргөтөл хийснээр	0	1	100 сая	Сумын ИТХ, ЗДТГ	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч
4.1.4		3 дугаар багийн Бартан, Хүрмийн гүүрний засвар	Замыг засаж ашиглалтад оруулснаао	0	1	35 сая	Сумын ЗДТГ	ЗДТГ
4.1.5	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.2.6 дахь заалт	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	Төлөвлөгөө боловсруулсан байна.	0	1	50 сая /эх үүсвэр тодорхой гүй/	Сумын ЗДТГ	Ажлын хэсэг
4.1.6	Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.5.3 дахь заалт	Жаргалант, сумын орон сууцнуудын дунд нийтийн эдэлбэр талбайд хүүхдийн тоглоомын талбай байгуулах	Гүйцэтгэлийн хувь	0	1	148 сая 15 сая	Сумын ИТХ, ЗДТГ	Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч
4.1.7		Ахуйн үйлчилгээний барилгын урсгал засвар, халаалтыг сайжруулах	Гүйцэтгэлийн хувь	0	Бүрэн ашиглалтад орсон байна.	5 сая	Сумын ЗДТГ	Аж ахуй нэгж
4.1.8	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	Нэрлэсэн жилийн хүрээнд төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тооцож ажиллах	Төлөвлөгөөний биелэлтээры	-	Төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлж ажилласнаар	Засаг даргын нөөцөөс	Сумын ЗДТГ	Төрийн болон төрийн бус байгууллага, иргэд

1	2	3	4	5	6	7	8	9
<b>ТАВ АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ</b>								
<b>5.1. Аюулгүй нийгэм-Эрсдэлгүй амьдрал-Амар тайван орчин</b>								
5.1.1	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.6, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1 дэх заалт	Гэрэлтүүлэгийг нэмэгдүүлэх, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийг сайжруулах	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Гэрэлтүүлэгтэй боловч гэмтэл их	Гэрэлтүүлэг-ийн тоог нэмэгдүүлсэн байна.	ОНХСан 19.318.800	Цахилгааны эрчим хүчний салбар	Сумын ЗДТГ
5.1.2	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.6, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1 дэх заалт	Камерын тоог нэмэгдүүлэх, засварлах	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх	2	Ашиглалтад сайн 10 ш камертай болсноор	17.000.000	Сумын ГХУСАЗС Зөвлөл	Цагдаагийн тасаг
5.1.3	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1 дэх заалт	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилсан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулж ажилласан байна.	Гэмт хэргийн илрүүлэлт сайжирсан байна.	Нөлөөллийн ажил-1 Цахим өдөр тутам	Урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээний тоо өссөн байх	7 сая	Цагдаагийн тасаг Сумын ГХУСАЗС Зөвлөл	Сумын ЗДТГ
5.1.4	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 8.1.2 дахь заалт	Хүчний байгууллагын албан хаагчдын амьдрах орон сууцныг шинээр барьж ашиглалтад оруулна.	Цагдаагийн тасгийн барилга ашиглалтад орсноор	Цагдаагийн тасгийн барилга баригдаж байгаа	100 хувь	-	Цагдаагийн тасаг	Сумын Засаг дарга

1	2	3	4	5	6	7	8	9
5.1.5	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн 8.1.3 дахь заалт	Иргэдийн цахим донтолт, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, үр дүнтэй ажлын тоо нэмэгдснээр	1	5	-	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Төрийн байгууллагын дарга, эрхлэгч нар
<b>5.2. Батлан хамгаалах салбар</b>								
5.2.1	Батлан хамгаалах тухай хууль Сумын Засаг даргын ажиллагааны хөтөлбөрийн 1.2.3 дахь заалт	16-25 насны залуучуудын дунд цэргийн албаны тухай хууль сурталчлах	Зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнгээр	1	2	-	Сумын ЗДТГ Цагдаагийн тасаг	Багийн Засаг дарга нар Ерөнхий боловсролын сургууль
5.2.2		Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүнгээр	0	1	1.000.000	Эрүүл мэндийн төв	Багийн Засаг дарга нар
<b>5.3. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх</b>								
5.3.1	Сумын Засаг даргын 2021-2024 оны ажиллагааны хөтөлбөрийн 8.2.1 дэх заалт	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, бодлогыг хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	0	1. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх 2. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ 3. мэргэжлийн ангийн хувцасыг шинэчлэх	ОНХСан 20 сая Гамшгаас хамгаалах сан-20 сая Засаг даргын нөөц	Сумын Засаг дарга ЭХАС	Иргэд, албан байгууллага, Багийн Засаг дарга нар
5.3.2		1. Мэргэжлийн ангийн дадлага сургууль зохион байгуулах 2. Уснаас эрэн хайх аврах ажиллагааны хамтарсан дадлага сургууль зохион байгуулах	Дадлага сургууль зохион байгуулсан тоогоор	1	2	2.000.000 төгрөг	ЭХАС	Аймгийн Онцгой байдлын газар Сумын Засаг дарга орлогч Мэргэжлийн анги



5.3.3		Нийт аж ахуйн нэгжүүдэд галын аюулгүй байдлын хяналт шалгалт зохион байгуулах, сурагчдад сургалт зохион байгуулах	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоогоор	1	2	-	ЭХАС	Сумын ЗДТГ
5.3.4	Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 8.2.3 дахь заалт	10х20 хэмжээтэй 4 автомашины гэрж барих	Гражтай болсон байх	40 хувь	100 хувь	20 сая	ЭХАС	Сумын Засаг дарга
<b>ЗУРГАА.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>								
<b>6.1.Ухаалаг засаглал-Цахим мэдээллийн тогтолцоо</b>								
6.1.1	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.3, Засгийн газрын 42 дугаар тогтоолоор баталсан "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-ын 3.7.1.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.7.1 дахь заалт	Иргэдэд зориулсан "Хамтдаа шийдье" төсөлт арга хэмжээг хэрэгжүүлэх	Хамрагдсан өрхийн тоо	150 өрх 450 иргэн	300 өрх 100 0 иргэн	-	Нийгмийн бодлогын мэргэжилтэн	Сумын ЗДТГ
6.1.2	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3, 4.3.2, Ухаалаг Баянхонгор хөтөлбөрийн 7.1.3, 7.4.1.2 дахь заалт	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйлчилгээний чанарыг сайжруулж, цахим мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт хийх	Үйлчлүүлсэн иргэдийн тоо, цахим системийн хөгжүүлэлтийн хувь	142	200	-	Хариуцсан мэргэжилтэн	Сумын ЗДТГ